

Нэг. 2015 оны үйл явдлын товчоон

- 2015.01.19 Шилэн кабелийн холболттой VPN сүлжээнд холбогдов.
- 2015.02.20 Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа ЯАГ-аас зохион байгуулсан сургалт, семинарт оролцов.
- 2015.02.21 Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа МУ-ын Ерөнхий аудитор А.Зангадтай үр дүнгийн гэрээ байгуулав.
- 2015.02.09 “МУ-ын терроризмын дотоод Нөхцөл байдал, төрийн нууцын тухай, түүнийг хэрхэн хамгаалах” талаар Тагнуулын газраас зохион байгуулсан сургалтанд бүх ажилтнууд хамрагдав.
- 2015.03.05 Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа аймгийн Аудитын газрын ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулав.
- 2015.04.20 Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитор Б.Эрдэнэзул нар мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах 14 хоногийн сургалтад хамрагдав.
- 2015.04.24 Орон нутгийн “Миний монгол” телевизийн “Иргэдээ сонсьё” нээлттэй нэвтрүүлэгт удирдлагын зөвлөлийн гишүүд оролцож, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгөв.
- 2015.04.26 Аймгийн ОБГ-аас зохион байгуулсан “Гамшгийн аюулаас хамгаалах, зарлан мэдээлэх нүүлгэн шилжүүлэх” сэдэвт сургалтанд бүх ажилтнууд оролцов.
- 2015.05.10 Төрийн хөндлөнгийн хяналтын байгууллагын 20 жилийн ойг тохиолдуулан мод тарих хөдөлгөөнд оролцож 20 ширхэг мод тарив.
- 2015.05.28 Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа “ Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын дүнг аймгийн ИТХ- д танилцуулж, хэлэлцүүлэв.
- 2015.06.04 Шинжээч Э.Эрдэнэзул, А.Дашбат нар Төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг өргөв.
- 2015.06.12 Архангай аймгийн Аудитын газар болон Сэлэнгэ аймгийн Аудитын газрын ажилтнуудын хамтарсан уулзалтыг Сэлэнгэ аймагт зохион

байгуулав.

- 2015.06.17 ММНБИ-аас зохион байгуулсан спортын 14-р их наадамд бүх мэргэшсэн нягтлан бодогчид оролцов.
- 2015.06.25 Говьсүмбэр аймгийн Аудитын газар болон Сэлэнгэ аймгийн Аудитын газрын ажилтнуудын уулзалтыг Сэлэнгэ аймагт зохион байгуулав.
- 2015.06.30 Эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийв.
- 2015.07.16-20 Хөндлөнгийн хараат бус Төрийн хяналтын байгууллага байгуулагдсны 20 жилийн ойн арга хэмжээнд бүх ажилтнууд оролцов.
- 2015.09.29 МУ-ын АТГ-аас зохион байгуулсан Нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлэх сургалтанд бүх ажилтнууд хамрагдав.
- 2015.09.28 Архивын урьдчилсан үзлэгт хамрагдаж “А” үнэлгээтэй шалгагдав.
- 2015.10.01 Аймгийн Аудитын газрын МТС -ын хүрээнд сургалт зохион байгуулав.
- 2015.10.14 ЯАГ-аас санхүүгийн тайлангийн аудитын онол арга зүйн талаар хийсэн онлайн сургалтанд хамрагдав.
- 2015.10.22 ЯАГ-ын Санхүүгийн аудитын газраас зохион байгуулсан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системийн СТАУС программын сургалтад бүх ажилтнууд хамрагдав.
- 2015.11.13 Хөндлөнгийн хараат бус Төрийн хяналтын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан бага хурал зохион байгуулав.
- 2015.11.25 Оны шилдэг тайлангийн уралдаанд тайлан явуулав.
- 2015.12.04 Аймгийн ИТХ-д 2016 оны орон нутгийн төсөвт төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал оруулав.
- 2015.12.05 Бүртгэл санхүүгийн ажилтны өдөрт зориулсан спортын арга хэмжээнд оролцов.
- 2015.12.24 Төрийн албан хаагчидтай хийсэн үр дүнгийн гэрээ дүгнэв.
- 2015.12.25 Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийв.

Хоёр. Ерөнхий зүйл

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь тайлант 2015 онд нийт 36 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснийг бүрэн биелүүлэв.

Аймгийн Аудитын газар нь 2015 онд Монгол улсын Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулиуд, УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитуудыг гүйцэтгэж ирлээ.

Монгол улсын Ерөнхий аудитор А.Зангадын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрөөр 6 гүйцэтгэлийн аудит, 4 нийцлийн аудит болон 153 байгууллагын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн болно.

Аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэлийн аудит 3, санхүүгийн аудитын дүнд тулгуурласан эрсдэлийн аудит 5-ыг хийлээ. Үүнээс 1 гүйцэтгэлийн аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэв.

МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрөөр хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитууд:

Нэг. Гүйцэтгэлийн аудит

1. “МУ-ын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”
2. “Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”
3. “Ажилтай орлоготой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт”

4. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”
5. “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүн”
6. “Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал” сэдэвт аудитуудыг гүйцэтгэж холбогдох тайлан, судалгааг хугацаанд нь Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэв.

Хоёр. Нийцлийн аудит

1. “Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын оношилгооны төв байгуулах төслийн хэрэгжилт”
2. “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдал”
3. “Засгийн газрын тусгай сангийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн”
4. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт аудитыг тус тус хийж тайлан, дүн, судалгааг Нийцлийн аудитын газарт хугацаанд нь хүргүүллээ.

Өөрийн төлөвлөгөөгөөр хийсэн гүйцэтгэлийн болон эрсдэлийн аудитууд:

а.Гүйцэтгэлийн аудит:

1. “Аймгийн ИТХ-аар баталсан зарим хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”
2. “Сэлэнгэ аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүн”
3. “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хувьчлал, дуудлага худалдааны үйл ажиллагааны үр дүн”

б.Эрсдэлийн аудит:


1. “Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа”
2. “Хушаат сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа”
3. “ТЭДС-ийн Хөтөл салбарын санхүүгийн зарим үйл ажиллагаа”
4. “ТЭДС-ийн Сэлэнгэ салбарын санхүүгийн зарим үйл ажиллагаа”
5. “Сэлэнгийн долгио чуулгын санхүүгийн зарим үйл ажиллагаа”

Бид 2015 онд хийгдсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн болон эрсдэлийн аудитуудаар нийт **10716.8 сая** төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн **97.8 сая** төгрөгийн акт, **10618.8 сая** төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичиж, биелэлтэд хяналт тавин ажилласнаар **75.8 сая** төгрөгийн акт, **10264.5 сая** төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлээд байгаа бөгөөд **22.0 сая** төгрөгийн акт, **354.3 сая** төгрөгийн албан шаардлагыг барагдуулах хугацаа хараахан болоогүй байна.

График 1 /сая.төгрөг/



График 2 /сая.төгрөг/



Өмнөх оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл тайлант онд нийт **147.8 сая** төгрөгийн акт, **12156.8 сая** төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, актын биелэлт **87.0 хувьтай**, албан шаардлагын биелэлт **97.2 хувьтай** тайлагнагдлаа. Төлбөрийн актын биелэлтийг хангуулан ажилласнаар 2015 онд орон нутгийн төсөвт **130.9 сая** төгрөгийг оруулаад байна.

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд үндэслэн арвилан хэмнэх чиглэлээр 47, үр ашиг дээшлүүлэх 81, үр нөлөөг сайжруулах 68, дотоод хяналтыг сайжруулах 147, бусад чиглэлээр 158 гэх мэтчилэн нийт 501 зүйлийн зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгсний 94,8 хувь нь биелэсэн дүн мэдээтэй тайлагнагдлаа.

График 3



2015 онд нийт **4088.3 сая** төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь хийж гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмжийг нийт төр, төсвийн болон төрийн бус байгууллагууд, иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд Сэлэнгэ аймгийн Аудитын газар гэсэн Facebook хуудас ажиллуулж аймгийн Аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, хийгдсэн аудитуудын дүнг тухай бүрд нь нийтэд мэдээлж, санал, хүсэлтийг аван, иргэдийн сонирхсон асуултад хариу өгөхөөс гадна аймгийн ИТХ-ын дарга, бүх гишүүдэд цахимаар, аймгийн Засаг дарга, түүний орлогч, ЗДТГ-ын дарга, Хөгжлийн бодлогын болон СТС-ийн хэлтсийн дарга нар, аудит хийгдсэн байгууллагуудад аудитын тайланг хэвлэн хүргүүлж ажиллалаа.

Мөн AUDIT.MN цахим хуудсанд хийж гүйцэтгэсэн аудитын тайлангууд, цаг үеийн ажлууд болон байгууллагын танилцуулга, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангуудыг оруулаад байгаа бөгөөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, холбогдох бусад үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд нь SHILENDANS.GOV.MN нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байна.

Үүнээс гадна МОНЦАМЭ -гийн Сэлэнгэ аймаг дахь сурвалжлагч, Сэлэнгийн мэдээ сонин, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад аудитын тайланг бүрэн эхээр нь электрон шуудангаар хүргүүлэх ажлыг тогтмолжуулж, Миний монгол телевизийн **“Иргэдээ сонсоё”** нэвтрүүлэгт удирдлагын зөвлөлийн гишүүд оролцож, төрийн аудитын байгууллага, аудитын дүнгийн талаар танилцуулан, иргэдийн хүссэн асуултад хариу өгч ирлээ.

Тайлант онд төрийн хөндлөнгийн, хараат бус хяналтын байгууллагын 20 жилийн ой тохиосонтой холбогдуулан харилцагчдын хүрээнд бага хурал зохион байгуулж “Төрийн хөндлөнгийн хяналтын байгууллагын хөгжил, шинэчлэл”, “Төрийн хөндлөнгийн хяналтын байгууллагын хараат бус байдал, ач холбогдол” , “Сэлэнгэ аймгийн Аудитын газрын үйл ажиллагааны үр дүн” сэдэвт илтгэлүүдийг хэлэлцүүлэн үйл ажиллагаагаа сурталчилсан болно.

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, их хэмжээний өр төлбөр, авлага үүсгэсэн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, ОНХС-гийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан зэрэг зөрчил гаргасан болон санхүүгийн тайлангийн аудитаар **“Хязгаарлалттай”**, **“Сөрөг”** санал дүгнэлт авсан Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Хушаат, Түшиг, Цагааннуур сумдын Засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч нар, Номгон, Түнхэл тосгоны цэцэрлэгийн эрхлэгч, Цагааннуур сумын ЕБС-ийн захирал, нягтлан бодогч, Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч зэрэг нийт 26 албан тушаалтанд МУ-ын Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн албаны тухай хуулиудын хүрээнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллав.

Аудитын явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй зөрчлүүдийг гүнзгийрүүлэн шалгуулах зорилгоор Цагааннуур сумын ЕБС-ийн захирал, нягтлан бодогч нартай холбоотой хэргийг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлээд байна.

Аудитын дүнгээр тавьсан актыг биелүүлэлгүйгээр 1-2 жил дамжсан, 10 гаруй албан тушаалтанд хамаарагдах 20,9 сая төгрөгийн төлбөрийг Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн болно.

Гурав. Гүйцэтгэсэн аудитын талаар

1. Санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар **нийт 65.9 сая** төгрөгийн төлбөрийн акт, **2505.2 сая** төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичиж 60,0 сая төгрөгийн акт, 2505.2 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлээд байна.

График 4



Өмнөх оноос шилжиж ирсэн 8.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 1776.0 сая төгрөгийн албан шаардлагыг тайлант онд бүрэн барагдууллаа.


Аудитаар арвилан хэмнэх 28, үр ашиг дээшлүүлэх 46, үр нөлөөг сайжруулах 27, дотоод хяналтыг сайжруулах 110, бусад 127 зэрэг нийт 338 зүйлийн зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд 1,021.7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,912.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4,935.6 сая төгрөгийн алдааг залруулан, залруулах боломжгүй, өөрөөр хэлбэл холбогдох хууль

эрхийн актуудыг зөрчсөн, хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой зөрчлүүдэд хөрөнгө төлүүлэх төлбөрийн акт, зөрчил арилгуулах албан шаардлага, аудитын зөвлөмжийг өгч биелэлтийг тооцон ажиллалаа.

Аудитаар 135 зөрчилгүй, 13 хязгаарлалтай, 4 сөрөг дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

График 5



А. Өөрсдийн аудиторруудаар:

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан “Аймаг, нийслэлийн Аудитын газар нь орон нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, орон нутгийн төсвийн жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж дүгнэлт гаргах” гэсэн бүрэн эрхийн хүрээнд төсвийн шууд, төвлөрүүлэн захирагчид болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны 81 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргав.

Мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авах үүднээс аудитын олон улсын стандарт, ҮАГ-аас гаргасан санхүүгийн аудитын гарын авлага, журмыг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол, ажил гүйлгээнүүдийг хянаж, аудитын горимыг хэрэгжүүлэн аудитын дүн, дүгнэлтийг боловсрууллаа.

Нэг. Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:




Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитад орон нутгийн төсөвт 103, тусгай зориулалтын шилжүүлгийн 130 байгууллага, 32 төсөл сан, орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж хамрагдаж, нийт 5,634.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс бүртгэл хөтлөлттэй холбоотой 3,176.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 45.3 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 1,976.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Аудитын явцад илэрсэн 2,188.2 сая төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тооцсон материаллаг байдлын түвшин / 2,200.1 сая төгрөг /-гээс бага байсан учир аймгийн ТЕЗ-ийн 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд **Зөрчилгүй** санал дүгнэлт өгөгдлөө. Аудитаар Орхонтуул, Ерөө, Түшиг, Хушаат, Зүүнбүрэн зэрэг 5 сумын ТЕЗ-ийн, Аймгийн ИТХ, Номгон тосгоны цэцэрлэг, Сүхбаатар сумын 3-р цэцэрлэг зэрэг 3 ТШЗ-ийн санхүүгийн тайланд **“Хязгаарлалттай-санал дүгнэлт**, Цагааннуур сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Түнхэл тосгоны сургууль, цэцэрлэг, Цагааннуур сумын сургууль зэрэг 4 санхүүгийн тайланд **“Сөрөг-санал дүгнэлт”** өгч, “Тариалан эрхлэлтийг дэмжих техник дундын үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзан, 12 сумдын ТЕЗ, 57 ТШЗ, 9 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд **“Зөрчилгүй-санал дүгнэлт”**-ийг өгсөн болно.

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаанд эзлэх залруулсан болон залруулагдаагүй алдааг хувьчлан графикаар харуулбал:

График 6



ТЕЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн нийт алдаа, зөрчлийг байгууллага, тусгай сан тус бүрээр, алдааны төрлөөр салган харуулбал:

1.1 Аймаг, сумдын төсвийн байгууллагуудын болон ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд илэрсэн бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулагдсан алдаа:

Санхүүгийн тайланд нөлөөлөхүйц, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3,176.3 сая төгрөгийн алдааг залруулав.

Залруулагдсан алдаа

Төрөл	Залруулагдсан буюу нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа /сая төгрөг/							
	үр дүн	мөнгөн гүйлгээ	орлого	мөнгөн хөрөнгө	авлага	өглөг	үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл	Бараа материал
Байгууллага	1502.8	18.8	43.2	87.2	193.7	3.1	873.0	57.3
Аймгийн хөгжлийн сан					10.5			
ОНӨААТҮГ	44.5	23.5	32.1		185.6	57.4	43.6	
дүн	1547.3	42.3	75.3	87.2	389.8	60.5	916.6	57.3

1.2. Хууль, тогтоомж, журам зөрчсөн алдаа, зөрчил түүний шийдэл:

ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад өглөг, авлага үүсгэсэн, төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй зэрэг 995.4 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаа

төрөл	Хууль тогтоомж зөрчсөн алдаа /сая төгрөг/				
	орлого	Үндсэн хөрөнгө	Авлага, өглөг үүсгэсэн	Төсвийн гүйцэтгэл	НИЙТ
Орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	335.8	7.4	232.9	390.5	966.6
ЗД-ын нөөц хөрөнгө				28.8	28.8
Нийт	335.8	7.4	232.9	419.3	995.4

1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, дүрэм, журмын зарим заалтыг зөрчсөн алдаа, зөрчил түүний шийдэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 107.0 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил илэрч, уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, зөвлөмж өгөв. Үүнд:

- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд 6 сумын соёл, эдийн засгийн өдрүүд арга хэмжээний 36,0 сая төгрөг, Сэлэнгэ ургац 2014 арга хэмжээний 30.0 сая төгрөг, нээлттэй хаалганы арга хэмжээний 25.0 сая төгрөг зэрэг нийт 91.0 сая төгрөгийн урсгал зардлыг суулган батлуулж, гүйцэтгэлээр 83.0 сая төгрөгийг зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэхь заалтыг зөрчсөн байна.

- Зүүнбүрэн сумын соёлын төвийн их засварын ажлыг улсын комисс хүлээн аваагүй байхад хүлээн авсан тухай актыг хуурамчаар үйлдүүлэн 6.0 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлсэн нь МУ-ын ЗГ-ын 2012 оны 151 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.17.7 дахь заалтыг зөрчсөн байна.

-Мандал сум ОНХС-гийн эх үүсвэрээс төсөвт сууж батлагдаагүй төсөл, арга хэмжээнд 10.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Залруулагдаагүй алдаа

Төрөл	Хууль тогтоомж зөрчсөн алдаа /сая төгрөг/	
	Төсвийн тухай хууль	НИЙТ
Аймгийн ОНХО	97.0	97.0
Мандал сум ОНХО	10.0	10.0
Нийт	107.0	107.0

1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд илэрсэн зөрчил, түүний шийдлүүд:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 769.3 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч, 2.4 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 766.9 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна.

Залруулагдаагүй алдаа

	Хууль тогтоомж зөрчсөн алдаа /сая төгрөг/						НИЙТ
	Зориулалт бус зардалд зарцуулсан.	Гүйцэтгэчийг зохих хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй	Зориулалт бус зардалд зарцуулсан.	Гүйцэтгэгчид санхүүжилтийг илүү шилжүүлсэн.	Техникийн болон улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон.	Иргэдийн санаал авалгүй ИТХ-ын тогтоол гаргаж а ажил гүйцэтгэсэн	
13 сумын ОНХС	5.9	182.5	5.9	2.4	24.6	553.9	769.3

1.5. Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой илэрсэн алдаа зөрчлийн шийдэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 310.5 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 10.5 сая төгрөгийн алдааг залруулан, 300.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Аймгийн хөгжлийн сангаас Аймгийн ИТХ-ын 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 47 дугаар тогтоолоор 300.0 сая төгрөгийг ХХОАТ-ын буцаан олголтын санхүүжилтэд зарцуулсан зөрчил илэрч, аудитаар зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

1.6. ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлүүд түүний шийдэл:

Урсгал ус, Гавшгай ус, Сэлэнгэ үйлчилгээ, Цөм сүрэг, Сэлэнгэ Зүүнхараа, Сэлэнгэ Энерго, Туулын хишиг, Цант орхон, Цагааннуур тохижилт, Сэлэнгэ барилга захиалагч зэрэг ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 403.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 116.8 сая төгрөгийн алдааг залруулан, үйлдвэрийн газрын удирдлагуудад зөвлөмж хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан болно.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд:

- Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “ Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”-ыг мөрдлөг болгон орон нутгийн байгууллагуудын нягтлан бодогч нараар санхүүгийн үйл ажиллагаа,

нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг бэлтгүүлж байх.

- Нягтлан бодох бүртгэлийг НББОУС, УСНББОУС, Сангийн сайдын тушаалуудын дагуу үнэн зөв хөтөлж, жил бүрийн санхүүгийн тайланд давтан гарч буй бүртгэл хөтлөлттэй холбоотой их хэмжээний алдаа, зөрчлийг арилгах, нягтлан бодогч нарын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх.
- Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн дагуу улс, аймаг, сумын төсвийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвийн орлогыг аймагт, аймгийн орлогыг суманд, сумын орлогыг Ойн анги зэрэг байгууллагууд төвлөрүүлэн зарцуулж буй зөрчлийг арилгах.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнаж байх.
- Авлагын дансны үлдэгдэлд бүртгэлтэй он дамжсан, эзэн хариуцагч нь тодорхойгүй, найдваргүй 277.1 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргуулж данснаас цэвэрлэх, Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас авах авлагыг барагдуулах, төсвийг зүй зохистой удирдаж шинээр авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын менежерүүдийн ажлыг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэн үр дүнгийн урамшууллыг олгохдоо холбогдох журам, зааварт нийцүүлж байх.
- Засаг даргын нөөц хөрөнгийг МУ-ын ЗГ-ын тогтоолоор батлагдсан журмын хүрээнд захиран зарцуулж, гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
- Төсвийн тухай хууль болон түүнтэй холбогдуулан гаргасан журам, зааврыг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгож, төсвийн гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- Сумдын ТЕЗ, орон нутгийн болон төсвийн тусгай зориулалтын байгууллагуудын төсвийн шууд захирагч нарын хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг авч, хууль эрх зүйн болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.
- Аймгийн хөгжлийн сан болон, сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг эргэн төлүүлэх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлж эргэлтэд оруулах, зээлийн үр өгөөжийг дээшлүүлэх.
- Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан, ТЕЗ, Төсвийн шууд захирагч нар болон түүний санхүү, бүртгэлийн ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28, Төсвийн тухай хуулийн 70-р зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах

Хоёр. Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн талаар:

Улсын төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 47 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт **2,278.2 сая** төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,759.3 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 20.6 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 498.3 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг өгч биелэлтийг тооцон ажиллалаа. Аудитаар Мандал сумын Улсын нөөцийн салбар, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Сэлэнгэ, Хөтөл дэхь салбар, ШШГЕГ-ын харьяа Хорих 433-р анги, Сайхан сум дахь ШШГА-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Хязгаарлалттай-санал дүгнэлт”, бусад 42 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Зөрчилгүй-санал дүгнэлт” өгөв.

2.1.Шадар сайдын багцад хамаарах аймгийн Онцгой байдлын газар, Хилийн Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчлал, хэмжил зүйн төв, Мандал, Орхонтуул, Баянгол сум дахь Улсын нөөцийн салбар зэрэг 7 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 111.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 25.4 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 2.3 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 74.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 8.3 сая төгрөгийн зөрчилд 18 зүйлийн зөвлөмж боловсруулан байгууллагын удирдлагуудад хүргүүлэн биелэлтийг тооцлоо.



Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
		дүн	дүн	дүн
ОБГ	3.6			3.6
МХГ	0.12		0.12	
ХМХГ	10.6	2.3		8.3
Мандал УНС	40.7		40.7	
Баянгол УНС	0.7		0.7	
Орхонтуул УНС	29.8		29.7	0.08
Дүн	85.5	2.3	74.8	8.38

2.2. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын багцад хамаарах Ерөө голын сав газрын захиргаа, УЦУОША зэрэг 2 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 13.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 13.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 3 зүйлийн зөвлөмж боловсруулан байгууллагын удирдлагуудад хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт	Албан шаардлага
		дүн	дүн
Ерөө голын сав газрын захиргаа	1.7		1.7
Дүн	1.7		1.7

2.3.Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 935.8 сая төгрөгийн алдаа илэрснээс 10.4 сая төгрөгийн алдааг залруулж 925.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 9 зүйлийн зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг тооцов.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт дүн	Албан шаардлага дүн
	дүн		
Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	2.9		2.9
НДХ	14.2		14.2
НДСан	908.3		908.3
Дүн	925.4		925.4

2.4.Хөдөлмөрийн сайдын багцад хамаарах Мандал, Сүхбаатар, Шаамар сум дахь МСҮТ, аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 220.1 сая төгрөгийн алдаа илэрснээс 165.1 сая төгрөгийн алдааг залруулан, 9.1 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 46.1 сая төгрөгийн зөрчилд 16 зүйлийн зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг тооцов.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт		Зөвлөмж	
		дүн	Албан шаардлага	дүн	дүн
Хөдөлмөрийн хэлтэс	9.1		9.1		
Мандал МСҮТ	20.3				20.3
Сант МСҮТ	2.2				2.2
Сүхбаатар МСҮТ	23.6				23.6
Дүн	55.2		9.1		46.1

2.5.Хууль зүйн сайдын багцад хамаарах Аймгийн Цагдаагийн газар, Сайхан, Мандал сумдын Цагдаагийн газар, Хилийн цэргийн 243, 101-р ангиуд, аймгийн ШШГА, Мандал дахь ШШГА, 433-р хорих анги, Улсын бүртгэлийн хэлтэс, ИХШХГ, Шүүх шинжилгээний албадын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 550.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 360.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 14.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 173.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 2.6 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангууллаа.



Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	акт	Албан шаардлага	зөвлөмж
Улсын бүртгэлийн хэлтэс	10.6		10.6	
Хилийн цэргийн 243 анги				
Хилийн цэргийн 101-р анги	19.1		19.1	
Шүүхийн шинжилгээний алба	0.12			0,12
Сэлэнгэ ШШГА	1.7			1.7
Мандал сумын ШШГА	34.7		34.7	
Хөтөл ШШГА	15.3	14.6	0.7	
Сайхан сумын Цагдаагийн хэлтэс	0.8			0.8
Мандал сумын Цагдаагийн газар	6.5		6.5	
Хорих 433-р анги	101.6		101.6	
Дүн	190.4	14.6	173.2	2.6

2.6.Сангийн сайдын багцад хамаарах Гаалийн газар, Татварын хэлтсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 23.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 4.9 сая төгрөгийн алдааг залруулан, 18.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 0.4 сая төгрөгийн зөрчилд 6 зүйлийн аудитын зөвлөмж өгч, биелэлтийг тооцсон болно.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт дүн	Албан шаардлага дүн	Зөвлөмж дүн
Татварын хэлтэс	0.4			0.4
Гаалийн газар	18.3		18.3	
Дүн	18.7		18.3	0.4

2.7. УЕП-ын харьяа аймгийн Прокурорын газар, Мандал сум дахь 1-р Прокурорын газар, Сайхан сум дахь 2-р Прокурорын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 214.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 203.8 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төлбөрийн акт, 16.7 зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэн биелэлтийг тооцов.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт дүн	Албан шаардлага дүн
Аймгийн Прокурорын газар	8.9		8.9
Сум дундын 1-р Прокурорын газар	7.9	2.5	5.4
Сум дундын 2-р Прокурорын газар	2.4		2.4
Дүн	19.2	2.5	16.7

2.8. ТЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газар

Тагнуулын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1.8 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 0.07 сая төгрөгийн алдааг залруулан, 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 0.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 2 зүйлийн зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг тооцон ажиллалаа.

Залруулагдаагүй алдаа / мян төг /

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт дүн	Албан шаардлага дүн
Тагнуулын газар	1.7	1.5	0.2
Дүн	1.7	1.5	0.2

2.9. Үндэсний Статистикийн хорооны харьяа аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2.0 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч, уг зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэн, биелэлтийг хангуулах арга хэмжээ авсан болно.

2.10. Зам тээврийн яамны харьяа Тээвэр, авто замын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 14.0 сая төгрөгийн зөрчил илэрснийг аудитын явцад залруулан, 3 зүйлийн зөвлөмж өгч биелэлтийг тооцов.

2.11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Сум дундын 20, 21, 22-р Шүүхийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 32.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 13.7 сая төгрөгийн алдааг залруулж, 21.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 4.0 сая төгрөгийн зөрчилд 4 зүйлийн зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан болно.



Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
		дүн	дүн	дүн
Сум дундын 20-р Шүүх	4.0			4.0
Сум дундын 21-р Шүүх	9.1		9.1	
Сум дундын 22-р Шүүх	12.0		12.0	
Дүн	25.1		21.0	4.0

2.12. ҮХААЯ-ны сайдын багцад хамаарах аймгийн ХХААГ, ТЭДСангийн Сэлэнгэ, Хөтөл дэхь салбаруудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 700.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 222.7 сая төгрөгийн алдааг залруулан, 477.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 7.0 сая төгрөгийн зөрчилд аудитын 11 зүйлийн зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг хангуулах арга хэмжээ авлаа.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
		дүн	дүн	дүн
Үйлдвэр хөдөө аж ахуйн газар	7.0			7.0
ТЭДСангийн Сэлэнгэ салбар	389.9		389.9	
ТЭДСангийн хөтөл салбар	88.0		88.0	
Дүн	484.9		477.9	7.0

2.13. Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын Сум дундын нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 220.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 136.9 сая төгрөгийн алдааг залруулж, 73.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 10.0 сая төгрөгийн зөрчилд 15 зүйлийн зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцов.

Залруулагдаагүй алдаа

Байгууллагын нэр	Алдааны дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
		дүн	дүн	дүн
Мандал сумын нэгдсэн эмнэлэг	74.8		64.8	10.0
Сайхан сумын Сум дундын нэгдсэн эмнэлэг.	8.5		8.5	
Дүн	83.3		73.3	10.0

2.14. Боловсролын сайдын багцад хамаарах аймгийн Боловсролын газар, Газар хөдлөлтийг бүртгэх дэд станцын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн



аудитаар ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй байна.

Б. Гурвалсан гэрээгээр хийлгэсэн аудит :

Сэлэнгэ аймгийн Аудитын газраас холбогдох хууль¹, журмын² дагуу төрийн өмчийн 1, орон нутгийн өмчийн 6 аж ахуйн нэгж болон 3 МСҮТ, боловсролын салбарын 62 байгууллага зэрэг нийт 72 байгууллагын санхүүгийн тайланд Дархан –

¹ МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дахь заалт

² МУ-ын Ерөнхий аудиторын 2009 оны 108 тоот тушаалаар батлагдсан “Гэрээгээр аудит хийлгэх журам”

уул аймагт үйл ажиллагаа явуулж буй “Далай ван Аудит” ХХК, “Ситико Аудит” ХХК, “ЦЭСБ Аудит” ХХК-иудаар гурвалсан гэрээний үндсэн дээр хөндлөнгийн аудит хийлгэсэн болно.



2.Гүйцэтгэлийн аудит

2.1.ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр:

2015 онд МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 6 гүйцэтгэлийн аудит хийж аудитын тайлан, дүн, судалгааг ҮАГ-т хугацаанд нь хүргүүлээ.

Гүйцэтгэлийн аудитаар 3774.9 сая төгрөгийн зөрчил илэрч 27.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 3747.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өглөө. Актын биелэлт 69.1 хувьтай, албан шаардлагын биелэлт 99.0 хувьтай тайлагнагдсан байна.

Арвилан хэмнэх 9, үр ашиг дээшлүүлэх 9, үр нөлөөг сайжруулах 17, дотоод хяналтыг сайжруулах 4, бусад 5 гэх мэт нийт 44 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, 1833.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцоолж харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

2.1.1. “МУ-ын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт,үр дүн”

Уг аудитын хүрээнд Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн судалгааг хугацаанд нь хийж явууллаа.

Үндсэн чиглэлийн биелэлтийг хөгжлийн урт ба дунд хугацааны зорилт, дэд зорилтуудын хүрээнд авч үзэхэд:

Нэг. Бодит салбарын хөгжлийн бодлогын хүрээнд “Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ”, “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлнэ”, “Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ”, “Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын

үйлдвэрлэлийг дэмжинэ”, “Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ”, “Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэсэн 6 зорилт, 13 дэд зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 4 дэд зорилт 50 хувийн, 1 дэд зорилт 70 хувийн, 5-н дэд зорилт 80 хувийн, 3-н дэд зорилт 100 хувийн биелэлттэй байна.

Хоёр. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд “Биологийн олон янз байдлыг хамгаална”, “Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ” гэсэн 2 зорилт, 5 дэд зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 4 дэд зорилт 80 хувийн, 1 дэд зорилт 90 хувийн биелэлттэй байна.

Гурав. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд “Ажилтай, орлоготой Монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ”, “Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн бодлого хэрэгжүүлнэ”, “Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг шинэчилнэ”, “Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх, боловсролын тогтолцоог шинэчилнэ”, “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна”, “Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээг иргэн бүрд хүргэх боломжийг бүрдүүлнэ”, “Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ”, “Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ” гэсэн 8 зорилт, 22 дэд зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 4 дэд зорилт 50 хувийн, 1 дэд зорилт 60 хувийн, 1 дэд зорилт 70 хувийн, 6 дэд зорилт 80 хувийн, 3 дэд зорилт 90 хувийн, 7 дэд зорилт 100 хувийн биелэлттэй байна.

2.1.2. “Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”




Гүйцэтгэлийн аудитаар “Сэлэнгэ аймаг нь 2014 оны төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргасан боловч улсын төсөвт төвлөрөх орлогыг аймагт, аймгийн төсвийн орлогыг сумын төсөвт, сумын төсвийн орлогыг Ойн анги зэрэг байгууллагад төвлөрүүлэн зарцуулах, дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчлүүд оршиж байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2014 оны орон нутгийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг 71,519.3 сая төгрөгөөр буюу төсвийн алдагдалгүйгээр төлөвлөж баталсан байна. 2014 онд татварын орлогоос 14,352.0 сая төгрөг, татварын бус орлогоос 1,541.6 сая төгрөг, урьд оны төсвийн хэмнэлтийн орлогоос 2,403.3 сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр

4,714.4 сая төгрөг, орлогын шилжүүлгээр ОНХС-гийн санхүүжилтэд 9,215.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 39,292.0 сая төгрөг зэрэг нийт 71,519.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График 7



Сэлэнгэ аймгийн хэмжээнд татварын орлогын төлөвлөгөөг 107.0 хувиар буюу 987,4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. ОТБИОАТ 91.1 хувийн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 98.9 хувийн, хог хаягдлын хураамжийн орлого 73 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бол ХХЭО 148 сая төгрөгөөр, УТХ 279.3 сая төгрөгөөр, ОХМБАТ 114.3 сая төгрөгөөр, АМБББАТО 244.4 сая төгрөгөөр тус тус давсан нь нийт дүнгээр татварын орлого давж биелэхэд гол нөлөөг үзүүлжээ.

Сэлэнгэ аймгийн 2014 оны төсвийн нийт зарлага 71,519.3 сая төгрөгөөр буюу өмнөх оныхоос 7266.1 сая төгрөгөөр илүү батлагдснаас 67,555.1 сая төгрөгийг зарцуулж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бөгөөд өмнөх оноос 5,718.6 сая төгрөгөөр буюу 9.2 хувиар нэмэгдсэн байна. Төсвийн нийт зарлагын 42.2 хувийг орон нутгийн төсвийн зарлага, 57.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн зардал эзэлж байна.

Төсвийн нийт зарлагын 49.3 хувийг цалин, НДШ-ийн, 8.7 хувийг тогтмол зардал, 12.4 хувийг бараа үйлчилгээний зардал, 16.3 хувийг татаас шилжүүлгийн, 13.4 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад татварын орлогын бүрдүүлэлт, төсвийн гүйцэтгэл, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн зарцуулалттай холбоотой зэрэг нийт 2164.7 сая төгрөгийн зөрчил илэрснийг Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 45.3 сая төгрөгийн нөхөн төлөх төлбөрийн акт, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,976.4 сая

төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, 143.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн болно.

2.1.3. “Ажилтай орлоготой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт



МУ-ын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний хавсралт 4-ийн дагуу “Ажилтай орлоготой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж заасан хугацаанд нь явууллаа. “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорилт тавьсан боловч 6 арга хэмжээ огт хэрэгжээгүй бөгөөд хөтөлбөрийн биелэлт дунджаар 54 хувьтай байна. “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн 22 зорилтын 49 арга хэмжээний 47.6 хувь нь хэрэгжсэн үр дүн гарчээ.



2.1.4. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”



Гүйцэтгэлийн аудитаар “Сэлэнгэ аймагт 2014 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 35 төсөл, арга хэмжээний 91.7 хувийг гэрээт хугацаанд байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд 10,285.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 04-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2014 оны төсөв батлах тухай” 38 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нийт 402.1 сая төгрөг баталжээ. Аймгийн ИТХ-ын 2014 оны 4-р сарын 4-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2014 оны тодотгосон төсөв батлах тухай” 42 тоот тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл, арга хэмжээг нийт 1,261.9 сая төгрөг байхаар тодотгосон байна.

2014 онд Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 12 төсөл, арга хэмжээнээс дөнгөж 4 нь л аймгаас хүргүүлсэн саналын үндсэн дээр шийдвэрлэгдсэн бол бусад 8 нь аймаг, орон нутгийн саналыг харгалзаагүй, өөрөөр хэлбэл тухайн байгууллага, хувь хүний санал дээр үндэслэгдэж батлагджээ.

Ингэж аймаг, орон нутгаас гаргасан саналыг харгалзалгүйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж байгаа нь зураг, төсвийг төсөв батлагдахаас өмнө бус батлагдсаны дараа нь эх үүсвэрт нь тохируулан хийлгэх үндэслэл болж байна. Нөгөө талаас жил бүр техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын



төлөвлөгөөнд суулгаж, таамгаараа санхүүжилтийн эх үүсвэр баталж байгаа нь хөрөнгө санхүүжилтийг хийгдэх ажлаас хэт өндрөөр төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, эсвэл хөрөнгө мөнгө дутагдснаас барилгын чанар, норм, нормативийг хангахгүй барилга угсралт, их засварын ажлууд хийгдэх нөхцлийг бүрдүүлж байна.

Сэлэнгэ аймагт 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр эрх шилжиж ирсэн 10,285.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл, арга хэмжээнээс 3,385.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 5,169.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.



Аймгийн ИТХ-ын 2014 оны 2-р сарын 12-ны 11 тоот тогтоолоор “Аймагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж буй барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг эхлүүлэх, гүйцэтгэх явцад техник, технологийн хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга байгууламжийг хугацаанд нь ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг сайжруулах зорилго бүхий **“Сэлэнгэ барилга захиалагч”** ОНӨААТҮГ-ыг байгуулж Сэлэнгэ аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд аймгийн ГХБХХэлтэс, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гэсэн 2 байгууллага захиалагчийн хяналтыг гүйцэтгэх болсон нь хөрөнгө оруулалтын ажлын хяналтын чанарыг эрс сайжруулж, ажлын ачааллыг багасгаж байгаа ч төсвийн зардлыг нэмэгдүүлэх, аймгийн ГХБХХэлтсийн ажилтнуудын үүрэг, хариуцлагыг сулруулах сөрөг үр дагаврыг үзүүлж байна.

Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Гүйцэтгэлийн аудитаар хөрөнгө оруулалтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй, санхүүжилттэй холбоотой 1019.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг зогсоох албан шаардлага өгч биелэлтэд хяналт тавин ажиллаа.

Цаашид зөрчил дутагдалгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах талаар Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ХБХ-ийн дарга, СТСХ-ийн дарга, ГХБХБХэлтсийн дарга зэрэг албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүллээ.

2.1.5. “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүн”

Аудитаар “Аймаг, сумдын засаг захиргаа болон мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хийгдэхгүй байгаагаас хууль бус алт олборлолт, ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах, нөхөн сэргээлт хийхгүй орхих зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2015 оны 6-р сарын байдлаар нийт 141.9 мянган га талбайд уул уурхайн салбарын 176 тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд үүний 58 нь хайгуулын, 118 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн 86 нь алтны, 1 нь зэсийн, 2 нь нүүрсний, 9 нь төмрийн хүдрийн, 20 нь барилгын материал олборлох зөвшөөрөл байна.

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн дийлэнх нь нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлыг журмын дагуу тооцсон байна.

Аудитын явцад хайгуулын үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль хамгаалах ажилд зарцуулахаар тусгасан зардлын судалгааг түүвэрлэн үзэхэд 2013 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 14 аж ахуйн нэгж тус бүр хайгуулын ажлын цар хүрээнээс хамааран 2,00.0-1,000.0 мянган төгрөгийн хооронд нийт 8,040.0 мянган төгрөг, 2014 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 17 аж ахуйн нэгж тус бүр 1,00.0-2,000.0 мянган төгрөгийн хооронд нийт 10,450.0 мянган төгрөг тусгасан байна.

Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим хуулийн этгээдүүд байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулагдах зардлын тооцооллыг хийгээгүй байна. Үүнд: /Жавхлант сумын нутагт хайгуул хийсэн “Скэинтгоулд” ХХК 2013 оны, Орхонтуул сумын нутагт хайгуул





хийсэн “Өсөх хүч” ХХК 2013, 2014 оны, “Их Шижир Эрдэнэ” ХХК 2013 оны, Орхон сумын нутагт хайгуул хийсэн “Эм юу Ар Си” ХХК 2013 оны байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөнд/

Иймд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг баталгаажуулахдаа нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлын тооцооллыг тусгуулж байх шаардлагатай байна.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжүүдээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байна. Орон нутгийн нөхөн сэргээлтийн барьцааны дансанд 2013 онд 21, 2014 онд 12 аж ахуйн нэгж барьцаа хөрөнгө байршуулжээ. Энэ нь нэг талаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН нь хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, нөгөө талаас сум орон нутгийн төр захиргааны байгууллагууд, байгаль орчны улсын байцаагчийн зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас шалтгаалж байна гэж дүгнэж байна. Баянгол, Жавхлант, Түшиг, Орхон, Ерөө, Орхонтуул сумд хайгуулын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төрийн сан дахь тусгай дансанд бүрэн төвлөрүүлээгүй бөгөөд төвлөрсөн хөрөнгийг төсөвт байгууллагуудын урсгал зардалд зарцуулсан байна.



Сум, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, байгаль орчны улсын байцаагчийн зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

Аймгийн хэмжээнд уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон газар, бичил уурхай эрхлэгчид, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлээгүй, шинэчилсэн бүртгэл хөтлөөгүй байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг холбогдох хуулийн дагуу төлөвлөж, санхүүжүүлэхгүй байгаа нь аймгийн байгаль орчныг хамгаалах, орхигдсон газруудыг нөхөн сэргээх чиглэлийн ажлууд хийгдэхгүй байх гол шалтгаан болж байна.

Биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөснөөс 2013 онд 18 хувиар, 2014 онд 4.1 хувиар тус тус дутуу хийсэн байна, Аймаг, сумдын засаг захиргаа болон мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хийгдэхгүй байгаагаас хууль бус алт олборлолт, ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах, нөхөн сэргээлт хийхгүй орхих зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна.

Аудитаар 36.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж 8.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 28.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж биелэлтийг ханган ажиллалаа.

2.1.6. Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал

“Хил орчмын байгаль орчныг хамгаалах ажилд хангалттай хэмжээний хөрөнгө төлөвлөж, санхүүжүүлж чадахгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийсэн болно.

Сэлэнгэ аймаг нь ОХУ-тай усаар 180 км, ойгоор 40 км, тал хээрээр 201 км-ээр тус тус хиллэн оршдог.

2013-2015 онд Сэлэнгэ аймгийн ОХУ-тай хил залгаа нутгуудад нийт 7 удаагийн ой, хээрийн түймэр гарснаас ОХУ-аас Монгол Улсад хил давж 1 түймэр, дотоодын түймэр 6 бүртгэгдсэн байна.



Аймгийн УЦУОШАлбанаас хил орчмын гол, мөрөнд хамаарах Цөх, Хиагт, Буур, Орхон, Сэлэнгэ, Зэлтэр зэрэг голуудаас жил бүрийн 4-11 саруудад дээж авч шинжилгээ хийж байна.

2015 оны байдлаар хилийн бүсийн 3 суманд ойн санг гэрээгээр эзэмшдэг 12 ААН, 52 нөхөрлөл гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн БОГ, ОБГ-ууд хамтран аймгийн Засаг даргын 2013 оны А/63 тоот захирамжаар “2013-2016 онуудад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө” батлуулан сумдад хүргүүлэн ажилласан ч зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.



2013, 2015 оны Сэлэнгэ аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах”, “Хил дамнан гарах ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хилийн зарим сумдад зурвас байгуулах” гэсэн 2 ажил, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэн ажилласан байна.

2013-2015 онуудад Алтанбулаг, Түшиг сумын хил орчмын бүсэд ОХУ-аас 1, дотоодын 6, нийт 7 удаагийн ой, хээрийн түймэр гарч, 47938,4 га талбайг хамран /28930,4 га хээр, 19008 га ой/, 5 965,7 сая төгрөгийн экологийн хохирол учруулж, 10,6 сая төгрөгийн шууд зардал гарсан байна.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
Аудит газар үндэслэл, бүрэн хэрэг Аудитын газар
Монгол Улсын Үндэсний Аудитын тухай болон
ОХУ-ын Тослооны тавимлын зорилго 2012 оны 2
дугаар сарын 20-ний өдөр байгуулсан байдал.
Урьдчилан Төрийн Аудитын газрын 2014 оны 12
дугаар сарын 17-ны өдөр 20 дугаар тогтоол,
Монгол Улсын Ерөнхий Аудитор Үндэсний
Аудитын газрын 2015 онд нийлүүлэх Аудитын
болон өмч, үйлчилгээний төлөвлөгөөг үндэсний
Төрийн Аудитын газрын тусгай тусгаарлагдсан
Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн үүрэг
хэрэг.



ТАГ: АТ/2015/0001/01

Хил орчмын ой, хээрийн түймрийн гаралт 2010-2012 оны мөн үеэс 12,5%-иар буурсан ч экологи эдийн засгийн хувьд ихээхэн хохирол учирсаар байна.

Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд *“Ерөө, Хараа, Орхон, Сэлэнгэ голын сав газарт усны тооллого явуулж, сав газруудын зөвлөгөөнийг зохион байгуулах”* арга хэмжээг аймаг, сумдын ЗДТГ, аймгийн БОГ-тай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ч хийгдээгүй байна.

Аймгийн УЦУОШАлбаны байгаль орчны шинжилгээний лаборатори нь жил бүр хил орчмын гол, мөрнүүд болох Зэлтэр, Хяраан, Хиагт гол, Сэлэнгэ мөрөнд гадаргын усны шинжилгээг хийж ирсэн байна. 2013 онд хийсэн шинжилгээний дүнгээр: маш цэвэр ангилалд: Зэлтэр, Хяраан, Цөх, цэвэр ангилалд: Орхон, Сэлэнгэ, бага бохирдолтой ангилалд: Буурь, маш их бохирдолтой ангилалд: Хиагт гол тус тус багтжээ. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид анхаарч ажиллах талаар холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгч, биелэлтийг тооцон ажиллав.

2.2. Аймгийн Аудитын газрын төлөвлөгөөгөөр:

Аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу 3 гүйцэтгэлийн аудит хийлээ.

2.2.1. “Аймгийн ИТХ-аар баталсан зарим хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн”



Аймгийн ИТХ-аар баталсан “Малын тэжээл”, “Цөлжилт”, “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн *“Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөөгүй, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах хэрэгтэй байна”* гэсэн дүгнэлтийг хийлээ.

Аймгийн эрсдэлийн сангаас бэлтгэсэн малын тэжээлийг хариуцах эзэнгүй орхисон ХХААГ-ын мэргэжилтний хариуцлага, үйл ажиллагаанаас шалтгаалж 12.5 сая төгрөгийн өртөгтэй тэжээл дутагдаж төлбөрийн акт тогтоолоо. Эзэн холбогдогчийг тогтоолгож төлбөрийг барагдуулахаар аймгийн Цагдаагийн газрын Эдийн засгийн албанд шилжүүлээд байна.



2.2.2. “Сэлэнгэ аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүн”



“ Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тайлант оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож төлөвлөж, санхүүжүүлээгүй бөгөөд уг орлогын ихэнх хувийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг хийлээ.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2013 онд орон нутгийн төсвөөс 507.8 сая төгрөгийн, Ойн судалгаа хөгжлийн төвөөс ойн арчилгаа огтлолын ажлын санхүүжилтэд 21.2 сая төгрөгийн нийт 529.0 сая төгрөгийг, 2014 онд орон нутгийн төсвөөс 387.9 сая төгрөгийн, БОНХЯ-наас ойн арчилгааны огтлолын ажлын санхүүжилтэнд 16.1 сая төгрөгийн нийт 403.9 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна. Аудитаар дараах зөрчил дутагдал илэрсэн байна.Үүнд:

- БОАЖГ-ын дарга нь тухайн байгууллагын нийт батлагдсан шатахууны зардлын 48,0 хувийг ганцаараа, 30,0 гаруй хувийг Улаанбаатарт ажиллахад зарцуулсан байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тайлант оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож төлөвлөж, санхүүжүүлээгүй бөгөөд уг орлогын ихэнх хувийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.
- Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-нд заасан баримт материалын шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжүүдийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

Аудитаар 2339.9 сая төгрөгийн зөрчил илэрч 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 2339.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн байна.



2.2.3.”Орон нутгийн өмчийн алба, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хувьчлал, дүүдлага худалдааны үйл ажиллагааны үр дүн”

Аудитаар “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хувьчлал, дуудлага худалдааны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс их хэмжээний зөрчил оршиж байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ.



МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77-р зүйлийн 1-д *“Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч байна”* гэж заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2010 оны 5-р сарын 25 өдрийн 48 дугаар тогтоолоор Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, Төрийн өмчийн хороо, аймгийн ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэр, журмуудыг хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлогыг орон нутагт зохион байгуулах зорилго бүхий аймгийн Орон нутгийн өмчийн албыг байгуулсан бөгөөд тус алба нь 2012 оны 11-р сараас шинэчилсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2010-2014 онд “Хүдэр дулаан”, “Сэлэнгэ эрчим хүч”, “Ой ан төв” зэрэг ОНӨААТҮГ-ууд, нийгмийн салбарын хувьчлалын хүрээнд “Арцат”, “Гүн нуур” хүүхдийн зуслангуудыг тус тус хувьчилсан байна.



Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн шийдвэрийн дагуу 2010-2014 онуудад нийт 14 удаагийн дуудлага худалдаагаар 247192,4 мянган төгрөгийн барилга, автомашин болон бусад үндсэн хөрөнгийг худалдсан байна. Аудитаар дараах дүгнэлт хийгдсэн болно. Үүнд:

- ❖ Аймгийн ИТХ нь орон нутгийн өмчийг хувьчлах, дуудлага худалдаа зохион байгуулах, худалдан борлуулах үйл ажиллагаатай холбогдох тогтоолуудыг хууль, журам зөрчин гаргасан байна.
- ❖ Арцат, Гүннуур хүүхдийн зуслангуудыг менежментийн үр дүнг харгалзан хувьчилсан үйл ажиллагаа бүхэлдээ холбогдох хууль тогтоомж, журмыг зөрчсөн байна.
- ❖ 2010-2012 онд хөрөнгө худалдсаны орлогыг “Аймаг хөгжүүлэх сан”-гийн дансанд төвлөрүүлсэн нь орон нутгийн төсвийн татварын бус орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлсөн байна.

- ❖ Холбогдох хууль эрхийн актыг зөрчин дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд дуудлага худалдааны орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.
- ❖ Аймгийн ОНӨА нь хувийн хэргийн баяжилт хийгээгүй, баримтын бүрдэл хангаагүй материалыг хүлээж авч барилга, автомашин болон бусад эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаж данснаас хасах саналыг аймгийн ИТХ-д оруулан шийдвэрлүүлсэн байна.

Аудитаар нийт 682.8 сая төгрөгийн зөрчил илэрч 6.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 676.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг хангуулав.

3.Нийцлийн аудит

2015 онд Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2 нийцлийн аудит хийж гүйцэтгэн, аудитын тайлан, дүнг УАГ-т хугацаанд нь хүргүүлээ.

Нийцлийн аудитаар нийт 3264.6 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн бөгөөд 2948.3 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар хариу ирүүлээд байна.

Арвилан хэмнэх 1, үр ашиг дээшлүүлэх 5, үр нөлөөг сайжруулах 7, дотоод хяналтыг сайжруулах 11, бусад 2 гэх мэт нийт 26 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн 858.4 сая төгрөгийн аудитын үр өгөөж тооцоолсныг харилцагч байгууллага хүлээн зөвшөөрлөө.

3.1. “Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын оношилгооны төв байгуулах төслийн хэрэгжилт”



Нийцлийн аудитын дүнд үндэслэн “Засгийн газраас хөдөөгийн хүн амд орон нутагт нь сүүлийн үеийн оношилгооны тоног төхөөрөмжөөр чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулсан боловч урвалж бодисууд нь хэт өндөр үнэтэй, зарим тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл дутуу нийлүүлэгдсэн, боловсон хүчнийг урьдчилан бэлдээгүй зэргээс шалтгаалан оношилгооны тоног төхөөрөмжийг бүрэн хэмжээгээр ашиглаж чадахгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн байна. Шинэчлэлийн Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн салбарын суурь

шинэчлэлийн жилд хөдөөгийн хүн амд орон нутагтаа чанартай оношилгоо, эмчилгээг хийлгэх боломжийг бүрдүүлэх үүднээс Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт 21 нэр төрлийн 1244,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгджээ.



Монгол улсын 2013 оны Төсвийн хуульд хөрөнгө оруулалт, төслийн арга хэмжээний төсвийг 50,0 тэрбум төгрөгөөр баталсан тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах үйл ажиллагааг ЭМЯ-наас зохион байгуулжээ. Харин 180,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Оношилгооны төвийн байрны засвар, тохижилтын ажлын сонгон шалгаруулалтыг аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан байна.

Оношилгооны төв байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ анхан шатны нэгжээс тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагын талаар санал, судалгаа авалгүйгээр төлөвлөсөн нь үндэслэл муутай болсон ба зарим тоног төхөөрөмжийн хувьд ашиглалтын зардал өндөртэй, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Тоног төхөөрөмж, урвалж бодисыг худалдан авахын тулд Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 2013 онд 289,4 сая төгрөг байсан бол 2014 оны гүйцэтгэлээр 484,2 сая төгрөг, 2015 онд 733,0 сая болж өссөн байна. Худалдан авалтаар зарим компанид давуу эрх олгосон нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах өнөөгийн шаардлагад нийцээгүй, бараа үйлчилгээний чанар, үнийн сонголт хийх эрх хязгаарлагдмал, төсөвт дарамт учрах эрсдлийг бий болгож байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Аудитаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Эрдэнэчимэгт ашиглалтгүй тоног төхөөрөмжийг бүрэн ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх, тоног төхөөрөмжийг ашиглах боловсон хүчнийг яаралтай бэлтгэх, оношилгоо шинжилгээнд ашиглагдах урвалж бодис, шаардлагатай материалыг аль болох хямд өртгөөр бэлтгэх, гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй Есүй-Ордон ХХК-иар дутуу нийлүүлэгдсэн багаж хэрэгсэл, тавилга эд хогшлыг бэлтгүүлэх, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авах асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх зэрэг 4 зүйлийн зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг тооцон ажиллалаа.

3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдал”



Нийцлийн аудитаар “ОНХС-гийн хөрөнгийн дийлэнх хувийг хэт жижиглэсэн, урсгал зардлын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байгаа нь уг сангийн гол зорилго болох орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах, ард иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх явдлыг төдийлөн хангаж чадахгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн байна.

2014 онд Сэлэнгэ аймгийн ОНХС-д 9,775.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6,634.3 сая төгрөгийг шилжүүлжээ. Үүнээс аймгийн ОНХС-д 4,013.6 сая төгрөг хуваарилсны 67.6 хувийг, сумдад 5,761.7 сая төгрөг хуваарилсны 68.1 хувийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Аймгийн ОНХС-аас 42 төрлийн 3,743.7 сая төгрөгийн, сумдад 191 төрлийн 5,105.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тус тус хэрэгжүүлжээ.

Аймаг, сумын Засаг дарга нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12-р зүйлд заасны дагуу ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж ажиллах ёстой байтал Сэлэнгэ аймгийн хэмжээнд иргэдээс санал авалгүйгээр 827.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 60.3.6, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.4 болон 12.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.



Нийцлийн аудитын хүрээнд явуулсан санал асуулгын “ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд та оролцож байсан уу?” гэсэн асуултад иргэдийн 49,8% нь “хааяа” оролцдог, 22,6% нь “огт үгүй” гэж хариулсан нь иргэдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

МУ-ын Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3 дахь “Хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн

үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтыг Мандал, Цагааннуур, Сүхбаатар сумдаас бусад нь хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, хяналтын зураг, төсөвгүйгээр төлөвлөж, батлуулснаар тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт хүрэлцэхгүйд хүрч он дамжиж удаашрах, нэмэлт санхүүжилт шаардагдах зэрэг эрсдлийг үүсгэж байна.

Нийцлийн аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, ашиглалт, хамгаалалтын байдлыг сумдад очиж нүдээр үзэхэд хэдийгээр шинээр нэмэгдсэн хөрөнгүүдийг сумдын ЗДТГ-ын болон багийн хөрөнгийн бүртгэлд бүртгэх ажил зохих хэмжээгээр хийгдсэн боловч тэдгээрийг манах манаач, урсгал засварын зардал болон бусад ашиглаж, хамгаалах санхүүжилтийг шийдвэрлээгүйгээс хариуцах эзэн тодорхойгүй, хөрөнгө эвдрэх, тоногдох байдал ажиглагдаж байлаа.



ОНХС-гийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжсэн 46 ажилд Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ, 2 ажилд Тээвэр авто замын газар, 141 ажилд сумдын ЗДТГ-ын зүгээс захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

Ихэнх сумдууд ОНХС-аар хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээг хүлээн авч, ашиглалтад оруулахдаа Засгийн газрын 2012 оны 151 тоот тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд зураг төсөв зохиогч, архивын байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна.

Аудитын дүнд үндэслэн аймаг, сумдын ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын орлогч, сумдын Засаг дарга нарт 17 зөвлөмж өглөө.

Нийцлийн аудитаар нийт 1111.1 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн байна.

3.3. “Засгийн газрын тусгай сангийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн”



Аудитаар “Авто замын сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй, зориулалт бусаар зарцуулсан, сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, захиран зарцуулах журам боловсруулж мөрдөөгүй зэргээр МУ-ын Авто замын тухай хуулийг зөрчсөн байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Сэлэнгэ аймгийн хувьд Дархлаажуулалтын сан, Соёл урлаг хөгжүүлэх сан, Автозамын сангийн үйл ажиллагааг хамарч аудит хийлээ. Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2014

онд ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанаас 148.6 сая төгрөгийн өртөг бүхий вакцин татан авсан байна.

Сэлэнгэ аймагт МУ-ын ССАЖСайдын 2014 оны 03-р сарын 13-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан СУХС-ийн санхүүжүүлэх ажлын төлөвлөгөөний 14,26-р заалтын дагуу 107.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна

Өмнөх оноос шилжсэн 5, тайлант оны 18 зэрэг нийт 23 төсөл арга хэмжээг орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж 411.6 сая төгрөг зарцуулсан байна.

Авто замын санг зохих журмын дагуу байгуулаагүй, хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй, зориулалтын бус зарцуулсан, устгалд оруулсан 20695 хүн тун вакциныг актаар баталгаажуулаагүй, Орхон, Түшиг сумдын зам засвар, тэмдэг тэмдэглээний ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй, гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэн өгөөгүй, соёл, урлаг хөгжүүлэх сангаас аймгийн Нэгдсэн музейд хөрөнгө худалдан авахдаа холбогдох журам баримтлаагүй зэрэг нийт 236.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдэж, биелэлтийг ханган ажиллалаа.



3.4. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”



Аудитаар “Шилэн дансанд мэдээлвэл зохих мэдээллийн 21.9 хувийг мэдээлээгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ. Аудитад Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамрагдах орон нутгийн төсөвт 213, улсын төсвийн 51 байгууллага, орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж, төрийн өмчит 1 компани, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа 82 аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гүйцэтгэж байгаа 47 хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамруулав. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 225 төрийн

байгууллага, 11 ОНӨААТҮГ, 37 сан цэс нээж холбогдох мэдээллийг байршуулжээ.

МУ-ын Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1–д зааснаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд 225 төсвийн байгууллага, 43 сан, 12 ОНӨААТҮГ зэрэг нийт 280 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим системд хамрагдахаас 1 ОНӨААТҮГ, 5 сан цахим хуудсанд бүртгэлгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих нь тодорхой бус гэсэн шалтгаанаар аймгийн ИТХ-аас бие дааж хяналт шалгалт хийгээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Санхүүгийн хяналт, аудитын албанаас тухай бүр гаргуулан авч танилцан, хуулийг хэрэгжүүлэн ажиллахыг сумдын ИТХ-д зөвлөжээ.



Алтанбулаг, Хүдэр, Цагааннуур, Хушаат, Түшиг, Баянгол, Баруунбүрэн, Сүхбаатар сумын ИТХ- нь Шилэн дансны тухай хуульд заасан эрх үүргийг ямар нэгэн хэмжээгээр хэрэгжүүлэн ажиллаж, нийт дансны 21.0-50.0 гаруй хувьд нь хяналт, шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар шилэн дансны мэдээлэл байршуулалт дунджаар 80.3 хувьтай гэсэн дүгнэлтийг хийж, мэдээлэл огт байршуулаагүй 25 байгууллагуудад зөвлөмж өгч, нэр бүхий 16 төсөвт байгууллага, 1 төрийн өмчит хуулийн этгээдэд сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг дутуу мэдээлсэн зөрчилд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байлаа.

Хяналт шалгалтаар shilendans.gov.mn цахим хуудсанд бүртгэлтэй байгаа нэр давхардсан, татан буугдсан, огт хамааралгүй 97 дансыг цэгцлэх талаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлэн ажиллаагүйгээс аймгийн Аудитын газраас хийсэн нийцлийн аудитаар 136 данс огт ашиглалтгүй байгаа зөрчил илэрсэн болно.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс мэдээлэл дутуу байршуулсан зэрэг зөрчлүүд илэрч 1926.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангаж ажиллалаа. Мөн аудитын дүнд үндэслэн аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, СТСХ-ийн дарга нарт зөвлөмж хүргүүлэв.



4.Эрсдэлийн аудит

4.Өөрийн төлөвлөгөөгөөр:

Аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу 5 эрсдэлийн аудит хийж гүйцэтгэв.

Эрсдэлийн аудитаар 1106.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 1101.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч акт,

албан шаардлагын биелэлт 100.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд орон нутгийн төсөвт 13.0 сая төгрөг төвлөрүүлсэн болно.

Аудитаар нийт 329.6 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож харилцагч хүлээн зөвшөөрсөн байна. Мөн арвилан хэмнэх 9, үр ашиг дээшлүүлэх 11, үр нөлөөг сайжруулах 8, дотоод хяналтыг сайжруулах 16, бусад 23 гэх мэт нийт 67 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг ханган ажиллалаа.

4.1. Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа



Аудитаар “Хүдэр сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа туйлын хангалтгүйгээс төр, төсвийн байгууллагуудад цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулах, тайлагнагдаагүй өр төлбөр барагдуулах, цалингийн сангийн хэмнэлтээс урамшуулал давхардуулан олгох, шатахуун, бичиг хэргийн зардлыг ажилтнуудын дансанд шилжүүлэх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчил их хэмжээгээр оршиж байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ.

Хүдэр сумын татварын орлогыг 2013 онд 168862,4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 173829,3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бол 2014 онд 310111,1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 382692,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Сумын хэмжээгээр урсгал санхүүжилт 100 хувь олгогдсон бөгөөд орон нутгийн төсөвт байгууллагууд 499844,7 мянган төгрөгийн, тусгай шилжүүлгийн байгууллагууд 1162013,4 мянган төгрөгийн зарлага гарган ажиллажээ. Урсгал санхүүжилтийн 48,4 хувийг цалин хөлс, 4,5 хувийг тогтмол зардалд, 7,6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 39,5 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн хэмнэлтээс 3446,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр төсвийн гүйцэтгэл 93.2 хувьтай тайлагнагджээ.

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2013 онд 264027,7 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 16786,7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 247241,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр, 2014 онд 313000,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн ч 88550,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 224450,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тус тус тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх санд 2013 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 80000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн хүүгийн орлогын 3085,3 мянган төгрөгийн нийт 83085,3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 76000,0 мянган төгрөгийн зээлийг, 2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 18000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтийн 18115,5 мянган төгрөгийн нийт 36115,5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 34000,0 мянган төгрөгийн зээлийг олгожээ.



Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудад нийт 149.4 сая төгрөгийн зөрчил илэрч 2.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 146.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдэж бүрэн биелүүллээ.

4.2.Хушаат сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа



“Хушаат сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүйгээс зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд болон эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах, тогтмол зардлын төлбөрийг бэлнээр гарган зориулалт бусаар зарцуулах, гэрээний дүнгээс илүү санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна” гэсэн дүгнэлтийг хийлээ.

Хушаат сумын төсвийн орлогод 2013 онд төлөвлөгөөгөөр 30479,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 28502,5 мянган төгрөг, 2014 онд 47111,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 44881,5 мянган төгрөг тус тус

төвлөрүүлсэн байна.

2014 онд сумын хэмжээгээр урсгал санхүүжилт 100 хувь олгогдсон бөгөөд орон нутгийн төсөвт байгууллагууд 337236,4 мянган төгрөгийн, тусгай шилжүүлгийн байгууллагууд 769951,7 мянган төгрөгийн зарлага гарган ажиллажээ.

Орон нутгийн байгууллагуудын урсгал санхүүжилтийн 52,8 хувийг цалин хөлс, 6,0 хувийг тогтмол зардалд, 37,9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 3,3 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2013 онд 221463,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 19270,1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 202192,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр, 2014 онд 297200,0 мянган

төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн ч 116600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 180600,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тус тус тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх санд 2013 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 100000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 13000,0 мянган төгрөгийн, нийт 113000,0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 113000,0 мянган төгрөгийн зээл олгосон бол 2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 8000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 20000,0 мянган төгрөгийн нийт 28000,0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 27000,0 мянган төгрөгийн зээл олгожээ.

Хушаат сумын төр төсвийн байгууллагуудад нийт 142.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрч 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 141.3 сая төгрөгийн албан шаардлага бичигдлээ.



4.3.Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбарын санхүүгийн зарим үйл ажиллагаа



“ТЭДС-ийн Хөтөл салбар нь өөрийн орлогыг арилжааны банк болон байгууллагын кассанд төвлөрүүлэн, төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулж байгаа нь батлагдсан төсөв хэтрүүлэх, төсөвт сууж батлагдаагүй зардал гаргах, зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчлийг хавтгайруулах нөхцөлийг бүрдүүлж байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ.

ТЭДС-ийн Хөтөл салбар нь:

- Өөрийн орлогыг бодит байдлаас хэт багаар төлөвлөж байна.
- Өөрийн орлогыг арилжааны банкин дахь харилцах данс болон байгууллагын кассанд бэлнээр төвлөрүүлэн, төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулж байна.
- Батлагдсан төсвийг хэтрүүлэх, төлөвлөгдөөгүй зардал гаргах, зориулалт бусаар болон зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулах зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг шууд зардлаар тайлагнах, худалдан авсан бараа материалыг материалын дансаар дамжуулалгүйгээр шууд мөнгөн хөрөнгөнөөс



зардлаар бүртгэх зэргээр УСНББОУС зөрчсөн байна.

- Улаанбуудай болон хор гербицидны үлдэгдлийг балансад тусгаагүй байна.

Эрсдэлийн аудитаар батлагдсан төсвийг хэтрүүлэх, төлөвлөгдөөгүй зардал гаргах, өөрийн орлогыг касс бэлнээр авч хяналтгүйгээр зарцуулах, бусдад хандив, бэлэг өгөх, зардлыг бодитоор тайлагнаагүй зэрэг нийт 153.7 сая төгрөгийн зөрчил илэрч 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 153.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичсэн бөгөөд акт, албан шаардлагыг бүрэн биелүүлсэн талаар хариу ирүүлээд байна.

4.4. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Сэлэнгэ салбарын санхүүгийн зарим үйл ажиллагаа



“ТЭДС-ийн Сэлэнгэ салбар нь өөрийн орлогыг арилжааны банкин дах харилцах данс болон байгууллагын кассанд бэлнээр авч төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулж байгаа нь батлагдсан төсөв хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах, НББ-ийн анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийх зэрэг эрсдэлийг үүсгэж, төсөв, санхүү, нягтан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд их хэмжээний зөрчил орших нөхцөлийг бүрдүүлж байна” гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ.

Тус байгууллагын 2013 оны санхүүгийн тайлан балансыг УАГ-ын Санхүүгийн аудитын газар, 2014 оны санхүүгийн тайлан балансыг аймгийн Аудитын газар баталгаажуулах аудит хийж тус тус “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгсөн байна. Тус салбар нь:

- Өөрийн орлогыг бодитоор төлөвлөөгүй байна.
- Өөрийн орлогыг төрийн сан дах харилцах дансанд бус арилжааны банкин дах харилцах данс болон байгууллагын кассанд орлого авсан байна
- Төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулсан байна.
- Батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.
- Төсвийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалтын бусаар зарцуулсан байна.
- Шатахууны зардлыг маршрут, жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулалгүйгээр бөөн дүнгээр зарлагдсан байна.
- Хүнсний материалын орлого, зарцуулалтын тайлан, хоолны өдөрлөг хөтлөөгүй байна.
- Санхүүгийн тайланг НББ-ийн анхан шатны баримтанд үндэслэн үнэн зөв, бодитой гаргаагүй байна.

- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
- Үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн болох улаанбуудай, хор бордооны тайланг иж бүрэн гаргаагүй, үлдэгдлийг балансад тусгаагүй байна.
- НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй зэргээр УСНББОУС-ыг зөрчсөн байна.

Аудитаар 658.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

4.5.Сэлэнгийн долгио чүүлгын санхүүгийн зарим үйл ажиллагаа



“Өөрийн орлогыг бодит нөхцөл байдалд үндэслэлгүйгээр, жил бүр тогтмол хэмжээгээр төлөвлөж байгаа нь өөрийн уран бүтээлээс төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нөөц, боломжийг алдагдуулж байна” гэсэн дүгнэлт хийлээ. Тус чуулга нь:

1. Нийт цалингийн санг дутуу тайлагнасан байна.
2. НДШ-ийн авлага үүсгэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.
3. Ажиллагсдын цалингаас суутгасан сахилгын арга хэмжээний суутгалыг орон нутгийн орлогод тухай бүр төвлөрүүлээгүй байна.
4. Өөрийн орлогыг бодит нөхцөл байдалд үндэслэлгүйгээр жил бүр тогтмол хэмжээгээр төлөвлөж байгаа нь өөрийн уран бүтээлээс төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нөөц, боломжийг алдагдуулж байна.
5. Өөрийн уран бүтээлийн орлогоос төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Аудитаар зөрчил арилгуулах 1.4 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн бөгөөд өгөгдсөн албаан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар хариу ирүүлээд байна.

Тав. Бусад ажлын талаар**5.1 Судалгаа , өгсөн саналын талаар:**

ҮАГ-аас ирүүлсэн албан тоотуудын дагуу дараах судалгаа, шинжилгээг хийж заасан хугацаанд нь хүргүүллээ. Үүнд:

1. “МУ-ын Эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудитад холбогдох судалгааг хийж хүргүүлсэн болно.
2. “Ажилтай орлоготой Монгол хүн” “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт” сэдвээр гүйцэтгэлийн аудитад холбогдох судалгааг хийж хүргүүлсэн байна.
3. Улсын болон орон нутгийн төсөвт байгууллагын талаарх үндсэн мэдээллийг СТАУС программд бүрэн шивж орууллаа.
4. 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд ирүүлсэн бүх судалгааг хугацаанд нь гаргаж явуулсан болно.

МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд ” *Сэлэнгэ аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын дүн* “-г 2015 оны 05 сард хуралдсан аймгийн ИТХ-д оруулж хэлэлцүүлэв.

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-дэх ”*Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулах*” гэсэн бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргаас аймгийн 2015 оны 12 сарын 04-нд хуралдсан ИТХ-д өргөн мэдүүлсэн 2016 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаар санал, дүгнэлт боловсруулж оруулсан болно.

5.2 Сургалтын талаар:

Аймгийн Аудитын газрын ажилтнууд ҮАГ болон аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан дараах сургалтуудад бүрэн хамрагдлаа. Үүнд:

1. Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа,
2. ММНБИ-аас зохион байгуулагдсан эрх сунгах 14 хоногийн сургалтад Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитор Б.Эрдэнэзул нар,
3. Аймгийн Орон нутгийн өмчийн албанаас зохион байгуулсан программын сургалтад аудитор Б.Эрдэнэзул,
4. “МУ-ын терроризмын дотоод нөхцөл байдал, төрийн нууцын тухай, түүнийг хэрхэн хамгаалах” талаар Тагнуулын газраас зохион байгуулсан сургалтад бүх ажилтнууд,



5. Аймгийн ОБГ-аас зохион байгуулсан “Гамшгийн аюулаас хамгаалах, зарлан мэдээлэх, нүүлгэн шилжүүлэх” сэдэвт сургалтад бүх ажилтнууд,



6. “Архивын бичиг баримт бүрдүүлэлт, хадгалах” сэдвээр Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан онлайн сургалтад бичиг хэргийн ажилтан У.Дөлгөөн,
7. МУ-ын АТГ-аас зохион байгуулсан Нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлэх сургалтад бүх ажилтнууд,



8. Аймгийн Аудитын газрын МТС-ын хүрээнд зохин байгуулсан 4 цагийн сургалтад бүх ажилтнууд,



9. УАГ-аас санхүүгийн тайлангийн аудитын онол арга зүйн талаар хийсэн онлайн сургалтад бүх ажилтнууд,
10. УАГ-ын Санхүүгийн аудитын газраас зохион байгуулсан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системийн СТАУС программын сургалтад бүх ажилтнууд тус тус хамрагдав.



11. МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан ТАБ-ын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын журмын дагуу аудитын менежер Б.Батмөнх мэргэшлийн тестийн болон ур чадварын шалгалтад хамрагдаж “онцгой сайн” буюу 96.2 оноотой үнэлэгдэв.



5.3 Хүлээн авсан өргөдөл , гомдол, хүсэлтийн талаар:

Төсөв хөрөнгө захиран зарцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрсдэлтэй асуудлыг хөндсөн чиглэлээр иргэдээс ирсэн дараах өргөдөл, гомдлын дагуу хянан шийдвэрлэж хариуг нь өглөө.Үүнд:

1. Аймгийн Ахмадын хорооны гишүүн Я.Гүрсүрэнгийн аймгийн Ахмадын хорооны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл,
2. Нэр бүхий иргэнээс Номгон тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Д.Баярхүүтэй холбоотой өргөдөл,
3. Түнхэл тосгоны цэцэрлэгийн ажилчдаас эрхлэгч Т.Лхагважавтай холбоотой өргөдөл,
4. Алтанбулаг сумын иргэн Ц.Болормаагаас ирүүлсэн сумын Халаалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол,
5. Сүхбаатар сумын иргэн С.Нарангэрэлээс тэтгэмжийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол,
6. Сайхан сумын иргэн Р.Шийлэгжамбалаас сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын талаар ирүүлсэн өргөдөл, гомдол
7. Шаамар сумын иргэн Д.Соёлбаатар, Ф.Серикбол нараас сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой гаргасан өргөдөл,гомдол
8. Ерөө сумын Бугант тосгоны иргэн Б.Пүрэвцэрэнгээс ойн нөхөрлөлийн үйл ажиллагаатай холбогдолтой ирүүлсэн өргөдөл, гомдол зэргийг хүлээн авч шалган, хариуг холбогдох этгээдүүдэд хүргүүлээ.

5.4 Албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах санал , хэрэгжилтийн талаар:

Аймгийн Аудитын газраас хийж гүйцэтгэсэн аудитуудаар хөрөнгө, санхүүгийн их хэмжээний зөрчил гаргасан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохин байгуулаагүй, ОНХС-гийн хөрөнгийг хуулийн хүрээнд зарцуулаагүй, санхүүгийн тайлангийн аудитаар Хязгаарлалттай болон Сөрөг санал дүгнэлт авсан зэрэг нийт 26 албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах санал, албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж биелэлтийг тооцон ажиллав. Үүнд:

1. Сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгдсэн тайлангаар “Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн, Зүүнбүрэн сумын Засаг дарга Б.Батчулуун, Төрийн сангийн төлөөлөгч С.Цэлмэг, Орхонтуул сумын Засаг дарга С.Эрдэнэбаяр, Төрийн сангийн төлөөлөгч Н.Цэндмаа, Хушаат сумын Засаг дарга Г.Галбадрах, Төрийн сангийн төлөөлөгч О.Цогбаяр, Түшиг сумын Засаг дарга Ц.Отгонтүйн, Төрийн сангийн төлөөлөгч Ц.Сарангэрэл,

- Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, Номгон тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Д.Баярхүү,
2. Санхүүгийн тайлан балансыг хугацаа хоцроож аудитад хүндрэл учруулсан Шаамар сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Алтантуяа,
 3. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “**Сөрөг**” санал, дүгнэлт авсан Цагааннуур сумын Засаг дарга Ч.Жаргалсайхан, Төрийн сангийн төлөөлөгч Ц.Эрдэнэчулуун, их хэмжээний өр төлбөр үүсгэн төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан ЕБС-ийн захирал Г.Сугар, нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэн, их хэмжээний авлага үүсгэсэн Түнхэл тосгоны ЕБС-ийн захирал Ч.Оюунгэрэл, мөн тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Т.Лхагважав,
 4. Төрийн сангийн хяналтын чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдаа зөрчил он дамжин гарч байгаа Хүдэр сумын Төрийн сангийн төлөөлөгч Т.Түмэндэлгэр,
 5. Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитаар их хэмжээний зөрчил гарган ажилласан сумын ЭМТ-ийн эрхлэгч Г.Нармандах, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг, цэцэрлэгийн эрхлэгч Д.Баярдэлгэр, сургуулийн захирал Г.Цэрэндамба, багийн засаг дарга Ц.Цэнбумаа, Т.Эрдэнэбат нарт,
 6. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитаар илрүүлсэн, дархлаажуулалтад хэрэглэсэн эм вакцины зарцуулалтанд хяналт тавиагүй ЭМГ-ын мэргэжилтэн Н.Эрдэнэдолгионд хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг тус тус холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хангуулан ажилласан болно.

5.5 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал. **хэрэгжилтийн талаар**

1. Төсвийн хөрөнгийг хувьдаа ашиглаж, төсвийг зохистой удирдаагүйгээс их хэмжээний өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчил гаргасан Цагааннуур сумын ЕБС-ийн захирал Г.Сугар, нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэн нарыг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэн шалгуулж байна.
2. Аудитын дүнгээр тавьсан актыг биелүүлэлгүйгээр 1-2 жил дамжуулсан Ерөө, Хушаат, Түшиг сумдын засаг дарга, төрийн сангийн төлөөлөгчид, Цагааннуур сумын цэцэрлэгийн эрхлэгч, аймгийн ХХААГ-ын дарга, Мандал сумын ШШГЕГ-ын хорих 433-р ангийн дарга, “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч нарын хариуцах 20.9 сая төгрөгийн актыг барагдуулахаар аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж холбогдох актын төлбөрийг барагдуулаад байна.

5.6 Төсөвт зардлын гүйцэтгэлийн талаар:

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь 2015 онд 11 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан бөгөөд 181.5 сая төгрөгийн батлагдсан төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 176.8 сая төгрөг зарцуулан , төсвийн өр, авлагагүй ажиллалаа.

Нийт зардлын 78.3 хувь буюу 177.9 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, дотоод албан томилолтын зардалд 5.3 хувь буюу 12.1 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 1.8 хувь буюу 4.1 сая төгрөгийг, бусад зардалд 14.6 хувийг буюу 18.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан дүн мэдээтэйгээр тайлагнагдсан болно.

5.7 Мэдээлэл, сурталчилгааны талаар:

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, болон хууль тогтоомжийн хэрэгжилт, аудитын дүн, тайланг олон нийтэд мэдээлэх, сурталчлах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хийж гүйцэтгэсэн аудитын бүх тайланг иргэдэд хүргэх зорилгоор аймгийн Аудитын газрын Facebook хуудсаар хэрэглэгчидтэй харилцаж байгаа бөгөөд аймгийн ИТХ-ын бүх төлөөлөгчид, аймаг, сумдын засаг дарга нарт электрон шуудангаар аудитын тайланг хүргүүлж санал хүсэлтийг авч ажиллаж байна.
2. МОНЦАМЭ-гийн Сэлэнгэ аймаг дахь сурвалжлагч, Сэлэнгийн мэдээ, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдтэй хамтран ажиллаж, хийж гүйцэтгэсэн аудитын тайлангуудыг цахимаар хүргүүлж байна.
3. Орон нутгийн “ Миний монгол” кабелийн телевизийн “Иргэдээ сонсоё” нээлттэй нэвтрүүлэгт Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор Б.Наранчимэг, аудитор Б.Эрдэнэзул нар оролцож Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг танилцуулсан бөгөөд иргэдийн санал хүсэлтийг сонсч, тэдний сонирхсон асуултад хариу өглөө.
4. Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг аймгийн ИТХ-д оруулж хэлэлцүүлэв.
5. Хөндлөнгийн, хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсны 20 жилийн ойд зориулж төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, түүхэн замнал, шинэчлэл, хөгжилтийн талаар олон нийтэд сурталчилах зорилгоор харилцагчдын хүрээнд бага хурал зохион байгуулж “Төрийн хөндлөнгийн хяналтын байгууллагын хөгжил, шинэчлэл”, “Төрийн хөндлөнгийн хяналтын байгууллагын хараат бус байдал, ач холбогдол” , “Сэлэнгэ аймгийн

Аудитын газрын үйл ажиллагааны үр дүн” сэдвээр аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор Б.Наранчимэг, С.Бат-эрдэнэ нар илтгэл тавилаа.



5.8 Дотоод ажлын талаар:

2015 онд Тэргүүлэх аудиторын 49 тушаал гарч, явсан бичиг 243, ирсэн бичиг 222, албан томилолтын үнэмлэх 17 тус тус бүртгэгджээ.

ҮАГ-аас зохион байгуулсан санхүүгийн тайлангийн, нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын дүн хэлэлцэх онлайн хуралд тухай бүрд нь холбогдох аудитор, шинжээчид оролцлоо.

Архангай, Говьсүмбэр аймгийн Аудитын газрын хамт олон Сэлэнгэ аймгийн Аудитын газрын үйл ажиллагаатай танилцаж, санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн, нийцлийн аудитын талаар санал бодлоо хэлэлцэж, харилцан туршлага солилцов.



Долоо хоногийн Даваа гариг бүр ажил төрлийн зөвлөгөөн хийж, өмнөх 7 хоногт хийсэн ажлын дүнг хүн бүр танилцуулан хэлэлцүүлж, дараагийн хийх ажлыг зөвлөн хэлэлцэж хэвшсэн болно.

Ерөнхий аудиторын тушаалаар ХАСХОМ хариуцсан ажилтныг томилуулан аудитор, шинжээчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, тайлан мэдээг хүргүүлэв.

Аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг ажилтнуудаар гаргаж, баталгаажуулж хэвшсэн болно.

2015 оны эхний хагас жил болон жилийн эцэст Тэргүүлэх аудиторын 2015 оны 06-р сарын 22-ны өдрийн А/17, 12-р сарын 22-ны өдрийн А/46 тоот тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” эд хөрөнгийн тооллого явуулж, ажиллагсдын эд хөрөнгийн картыг шинэчлэн хөтлөв.

Тэргүүлэх аудиторын зүгээс аймгийн Аудитын газрын аудитор, шинжээчидтэй үр дүнгийн гэрээ, үйлчилгээний ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр дүгнэсэн болно.

Аймгийн Аудитын газар байрладаг өргөтгөлийн барилгад урсгал засвар, техник тоног, төхөөрөмж, албан ажлын авто машинуудад тухай бүрд нь холбогдох үйлчилгээ хийж, ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангав.

Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь “Төрийн аудитын үйл ажиллагааг хараат бус, шударга, мэргэжлийн, найдвартай зарчмын дагуу гүйцэтгэж төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж, 2015 оны зорилтоо бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА